

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
БОЛОВСРОЛ СОЁЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ**

Гар бичмэлийн эрхтэй ©

ЧУЛУУНЫ БАТНАЙРАМДАЛ

**Үр хөврөлийн хөгжлийн үе шатыг
Дорнын болон Өрнийн анагаах ухааны
онолоор тайлбарлах нь**

/Е-720180 Уламжлалт анагаах ухаан/

*Анагаах ухааны магистрын
зэрэг горилсон бүтээлийн хураангуй*

**Улаанбаатар хот
2005 он**

Судалгааны ажлын үндэслэл:

XX зууны 50-иад оноос эхлэн Дорно дахины анагаах ухаан судлал хэмээх шинжлэх ухааны шинэ чиглэл бий болсноор 2000-3000 жилийн түүхтэй эртний Энэтхэгийн Аюурвед, Хятад, Түвд, Монголын уламжлалт анагаах ухааны онол, оношлогоо, эмчилгээ, засал, эмт бодисын судалгааг орчин үеийн онолын болон эмнэлзүйн шинжлэх ухаанд эд, эрхтэн, эсийн түвшинд судалж, олон сонирхолтой зүй тогтлыг илрүүлсээр байна.

Өнөөг хүртэл дорно дахины анагаах ухааны Хий, Шар, Бадган, Инь-Янгийн, Таван махбодын онол, оношлогоо, эмчилгээний аргууд нь гол төлөв хийсвэр сэтгэлгээ, гүн ухааны бясалгал, оюун дүгнэлт дээр тулгуурлан бий болсон гэж олон орны судлаачдын үздэг. Харин биеийн бүтэц судлал, бодит шинжилгээний аргууд дутагдалтай буюу ховор байдаг гэсэн ойлголт бий болжээ. Гэтэл одоогоос 2500 - гаад жилийн тэртээд Энэтхэг, Түвд, МУАУ-д “Ургийн хөгжлийг” үр тогтохоос авахуулаад төрөх хүртэл хугацааг дүрслэн үзүүлсэн, гардан хийсэн бүтэц зүйн судалгаа шинжилгээний талаар “Аштангхридая”, “Жүдши”, Алтан хадмал”, “Бидэр онбу”, “Эм заслын саран хаан” зэрэг судар номуудад бичсэн нь тухайн зүйлийг нотлох баримт болсон юм.

Тэгвэл одоогоос 2500-3000 жилийн өмнө УАУ-нд үр хөврөлийн тухай ном сударт тэмдэглэсэн байхад орчин цагийн анагаах ухаанд үр хөврөлийн тухай асуудал XVI зууны үеэс Андрей Везалий морфологийн шинжлэх ухааны суурийг тавьснаар анх эхэлсэн түүхтэй.

Орчин үед хүний үр хөврөлийг молекул, генетикийн түвшинд судлаж байна. Генийн инженерчлэл, хүнийг хувилах хуулбарлах зэрэг олон зүйл шинжлэх ухаанд буй болсон өнөө үед дорнын анагаах ухааны тайлбарлагдаагүй байгаа үр хөврөлийн тухай онолуудын мөн чанар, сүнсний тухай ойлголт, хөврөлийн хүйс урвуулах арга, хүрдний тухай зэрэг нууцлагдмал зүйлсийг шинэ түвшинд гаргаж ирэх нь зайлшгүй тулгамдсан асуудал болж байгаа юм.

Ийм учраас бид судалгааны ажилдаа үр хөврөлийн хөгжлийн үе шатанд гарах зарим өөрчлөлтийг дорно дахины анагаах ухааны болон орчин үеийн анагаах ухааны онолуудыг харьцуулан судлах шаардлагатай гэж үзэж уг судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

Судалгааны ажлын зорилго:

Үр хөврөлийн хөгжлийн үе шатыг тайлбарласан дорно дахины болон орчин үеийн анагаах ухааны онолыг харьцуулан судлах.

Судалгааны ажлын зорилт:

Дээрх судалгааны ажлын хүрээнд үр хөврөлийн хөгжлийн онолын харьцуулсан судалгаагаар дараах зорилтыг тавьсан. Үүнд:

1. Үр хөврөлийн хөгжлийн талаарх дорно дахины анагаах ухааны хий, шар, бадган, арга билэг, таван махбодын онолын үндсийг эх зохиол, сурвалж бичигт тулгуурлан судлан тогтоох.
2. Үр хөврөлийн хөгжлийн орчин үеийн анагаах ухааны Carnegie-23 үе шаттай ДДАУ –ны онолыг харьцуулах
3. Биеийн 36 махбод буюу эрхтэн систем бүрэлдэн тогтох онолыг үр хөврөлийн хөгжлийн ойлготтой харьцуулан судлах
4. Үр хөврөлийн хөгжлийн үед үндсэн 3 судаснаас үүсэх хүрдны тухай ойлголтыг шинжлэх ухааны үүднээс тодруулах

Судалгааны ажлын шинэлэг тал :

- Үр хөврөлийн хөгжлийн талаарх дорно дахины анагаах ухааны болон өрнийн анагаах ухааны онолын харьцуулсан судалгаа хийснээр өрнө, дорнын анагаах ухааны зарим нэгдмэл зүй тогтлуудыг илрүүлсэн.
- Дорнын анагаах ухаан дахь хүний хөврөлийн тухай асуудлуудаас одоог хүртэл орчин үеийн шинжлэх ухаанд нууц нь тайлагдаагүй байгаа тухайлбал сүнс, биед байгаа энергийн төвүүд, хүрд зэргийг шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбарлах оролдлого хийсэн.

Судалгааны ажлын ач холбогдол

- Үр хөврөлийн хөгжлийн онолын талаарх харьцуулсан судалгаа хийснээр онолын шинжлэх ухаан болон эмнэлзүйн шинжлэх ухааны нэгдмэл байдлыг буй болгоно.
- Өвчний эмнэлзүйн хувиралтыг илрүүлэх, эмгэг жамыг тайлбарлах, эмчилгээ оношлогоо, сургалт, судалгаанд хэрэглэх практикийн ач холбогдолтой.

Ажлын бүтэц хэмжээ

Магистрын ажил нь монгол хэл дээр 65 хуудсанд бичигдсэн нэг сэдэвт бүтээл бөгөөд зураг 14, хүснэгт 7, бүдүүвч 6, удиртгал, хэвлэлийн тойм, судалгааны арга ба материал, үр дүн, хэлцэмж, дүгнэлт, тойм, ном зүй зэргээс бүрдэнэ.

Хамгаалахаар дэвшүүлж буй үндэслэл

- Дорно дахины анагаах ухааны хөврөлийн тухай ойлголтыг орчин үеийн үр хөврөл судлалын шинжлэх ухааны онолтой харьцуулсан судалгааны үр дүн
- Хөврөлийн үүсэл хөгжлийг үндсэн 3 судас, үр хөврөлийн гурван давхаргатай харьцуулан судлаж төсөөтэй болон ялгаатай талыг тодруулсан.
- Дорно дахины анагаах ухааны онолоор ум, ром, жанма судасны зангилаанаас хүрд, бие махбодид байрладаг энергийн төв, биеийн болон ургал мэдрэлийн үйл ажиллагаатай хэр зэрэг уялдаа холбоотойг тайлбарласан.

Судалгааны үр дүнг хэлэлцүүлсэн байдал

1. Судалгааны ажлын үр дүнгээр БИОЛОГИ – АНАГААХ V – симпозиум, Мастер – 2002 эрдэм шинжилгээний бага хурал, МУИС – ийн Буддын соёл судалгааны төвийн ЭШ-ний хурал 2005 он, ЭМШУИС-ийн СУДЛААЧ–3 эрдэм шинжилгээний бага хуралд илтгэл хэлэлцүүлсэн.

Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй:

- Судалгааны ажлыг түүхийн герменевтик ба логик арга зүйг удирдлага болгон эх бичиг болон сурвалж бичиг судлалын үүднээс харьцуулан задлан шинжлэх аргыг хэрэглэсэн болно
- Судалгааны эх сурвалж, хэрэглэгдэхүүнээр :
 - Дармаамаарамба Лувсанчойдог. Алтан хадмал. “Бие тогтох ёсны бүлэг” Уйгаржин
 - Дэсридсанжаажамц. Хөх бидэр “Бие тогтох ёсны бүлэг” Төвд хэлээр
 - Сурхарвалодойжалбу. Дээдсийн таалал “Бие тогтох ёсны бүлэг” Төвд хэлээр
 - Keith I. Moore, “The developing human” 1988. Англи
 - 29. Sylvia S. Mader. “Human biology” 1992. Англи
- Харьцуулалтын аргаар:
- ДДАУ- ы онолоор хүний үр хөврөлийн хөгжлийн үе шатыг Carnegie -23 гаргасан ангилалтай харьцуулах.
- Үр хөврөлийн хөгжлийг дорнын ба өрнийн гариг тус бүртэй нь харьцуулах.
- Биеийн 36 махбодын хөгжилтийг үндсэн 3 судас, эндо, экто, мезодерм, органогенезын хөгжлийн үе шаттай харьцуулан судлах.